



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

Г “Номин карт ББСБ” ХХК-ийн Г
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Номин карт ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2013 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад сунгалтын талаарх тэмдэглэгээг 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн дотор хийлгэхийг “Номин карт ББСБ” ХХК /Ш.Энхбаяр/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

800517